

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЕСӨНЗҮЙЛ СУМ



**ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ**

Мөнхбулаг
2025 он

**“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ОРОН НУТАГТ ХАМААРАХ ЗААЛТЫГ
ЕСӨНЗҮЙЛ СУМАНД 2025 ОНЫ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2025.12.25

Мөнхбулаг

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6
Нэг. АТҮХөтөлбөр зорилт 3.3.1. Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэхдээ баримт, судалгаа, зөвлөмжийг үндэслэн тэдгээрийн бодит оролцоог хангана.					
3.3.1.4 Авлигатай тэмцэх зорилго бүхий, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжиж ажиллах	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	Дэмжлэг үзүүлсэн байна..	Засаг даргын Тамгын газарт 95255006 дугаартай нээлттэй утсыг ажлын найман цагаар ажиллуулан иргэдийн санал хүсэлт болон авлигын талаарх мэдээллийг иргэд чөлөөтэй мэдээлэх боломж нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн Засаг даргын Тамгын газрын “Өвөрхангай Есөнзүйл ЗДТГазар” нэртэй фейсбүүк хаяг, Esunzuil.ov.gov.mn нэртэй пэйж хуудсаар иргэдээс санал хүсэлтийг 24 цагийн турш аван ажиллаж байна.	100
3.3.1.5 Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.	-	Олон нийтийн хяналтыг нэмэгдүүлсэн байна.	Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Багийн иргэдийн нийтийн хуралд Албан байгууллагууд, албан хаагч нарын ажлын гүйцэтгэлийг тайлагнах ажлыг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна.	100
9.2.1 Үндэсний контентыг бүтээж, авлигыг үл тэвчих үзлийг олон нийтэд төлөвшүүлнэ.					
9.2.1.1 Байгууллагын цахим хаягт авлигын тухай хууль тогтоомжийг сурталчлан ажиллах	Мэдээллийг байршуулсан байна.	Тухай бүр байршуулан ажиллаж байгаа.	2 доошгүй мэдээллийг байршуулсан байна.	Esunzuil.ov.gov.mn байгууллагын цахим хаягт авлигын тухай хууль тогтоомжийг сурталчлан ажиллаж байна.	90

9.2.1.2 Орон нутгийн олны танил хүмүүсээр шударга ёсны чиглэлээр нөлөөллийн постер, контент бэлтгэн түгээх	Нэгээс дээш контент бэлтгэсэн байна.	-	1 доошгүй контент	Албан байгууллагын дарга, эрхлэгч болон төрийн албан хаагч нарт авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг тус бүр зохион байгуулан ажиллалаа. Мөн авлигын эсрэг хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон төлөвлөгөөний биелэлт, мэдээ мэдээллийг http://esunzuil.ov.gov.mn/ цахим хуудсанд байршуулан иргэдэд сурталчилна ажиллаж байна.	90
9.2.2 Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэх соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, мэдээлэл солилцох сувгийг хөгжүүлнэ.					
9.2.2.1 Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэх сумын цахим хаяг, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	Хамрагдсан хүний тоо	-	50	Авлигын эсрэг хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон төлөвлөгөөний биелэлт, мэдээ мэдээллийг http://esunzuil.ov.gov.mn/ цахим хуудсанд байршуулан иргэдэд сурталчлах ажил хэвшээд байна.	100
9.2.2.2 Орон нутагт зохион байгуулагдаж буй спортын тэмцээн уралдааны үеэр авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр сурталчилгаа хийх	Зохион байгуулсан үйл ажиллагаа	-	5	Албан байгууллагын албан хаагч болон орон нутагт зохион байгуулагдаж буй спортын тэмцээн уралдааны үеэр цагдаагийн албан хаагч нартай хамтран авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр сурталчилгаа хийн уриалга гарган ажилласан.	100
9.3.3 Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.					
9.3.1 Насан туршийн боловсролоор дамжуулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцуулах, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа,	Хамрагдсан иргэдийн тоо	-	10.000	Сумын Засаг даргын Тамгын газар аймгийн Насан туршийн боловсролын газартай хамтран орон нутагт "Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцуулах, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх" сургалт сурталчилгааны ажлыг хийгээд байна.	100

нөлөөллийн аяныг зохион байгуулах					
9.4. 1 Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэх ёс зүй, ёс суртахууны зөв төлөвшил олгоход чиглэсэн сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг насны ангилал, орчин үеийн чиг хандлагад нийцсэн байдлаар судалгаанд тулгуурлан боловсруулна.					
9.4.1.1 Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэх ёс зүй, ёс суртахууны зөв төлөвшил олгох хүүхдэд хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	Нийт сурагчдын эзлэх хувь	-	30.0	Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, гэр бүлийн үнэ цэнэ, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг зэрэг мэдээ мэдээлэл, зөвлөмж зөвлөгөөг болон бусад видео контент, рилүүдийг Есөнзүйл сумын хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгаалал цахим пэйж хуудсаар дамжуулан нийт ард иргэдэд түгээн ажиллаж байна. 2025 оны 05-р сарын 13-ны өдөр сумын Засаг дарга албан байгууллагуудын Эцэг эхийн зөвлөлд Олон улсын гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай 01/55 албан тоот хүргүүлэн ажиллалаа. 2025 оны 05-р сарын 23-ны өдөр Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас төлөөлөгчдийн нэрэмжит "НЭГ ГЭР БҮЛ, НЭГ ХАМТ ОЛОН" уриатай гэр бүлийн өдөрлөг зохион байгууллаа. 2025 оны 05-р сарын 15-ны өдөр ЕБС-ийн хамт олон нь байгууллагын ЕБС-д суралцдаг хүүхдүүд, ажилладаг эцэг эхчүүдийн дунд "Бид хүүхдээ хэрхэн мэддэг вэ?" үйл ажиллагаа зохион байгууллаа. Нийт 24 эцэг эх, 24 хүүхэд асуулгад оролцлоо. Энэ үйл ажиллагаанд оролцсон эцэг эхчүүдийг сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, алдаршуулах зорилгоор видео контент	100

				хийж сургуулийн цахим хуудсанд байршуулсан.	
9.4.1.2 Хүүхдийг номоор дамжуулан төлөвшүүлэх зорилгоор “Номын сан-Хөгжлийн орчин” үйл ажиллагааг зохион байгуулах	Зохион байгуулсан ажиллагааны хэрэгжилтээр	-	1	“Номын сан-Хөгжлийн орчин 2025”, “Хаврын номын баяр” арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан байна. Үүнд: Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Номын сангийн дэргэлэх номын клубийг шинээр гишүүний бүрэлдэхүүнтэйгээр нээж, ном уншдаг өдөр, Зөөврийн номын сангийн сохор сонголтын өдөр, бүтээлч уншлага зэрэг нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Өвөрхангай аймгийн төв номын сангаас зохион байгуулсан “ҮГИЙН ЧИМЭГ” богино өгүүллэгийн уралдаанд номын клубийн 2 гишүүн амжилттай оролцсон. Хавар болон намрын номын баяр арга хэмжээг улс орон даяар нэгэн зэрэг тэмдэглэн өнгөрүүлэх болсонтой холбогдуулан дараах үйл ажиллагааг мөн зохион байгуулсан. Үүнд: Номын сангийн тэргүүний уншигч хамт олон, Номын сангийн тэргүүний уншигч сурагч, Үлгэрч хүүхэд цахим уралдаан, Бяцхан зохиолч шүлгийн уралдаан, Ирээдүйн номын сан гар зургийн уралдаан зэргийг зохион байгуулж тус тус 1,2 дугаар байрыг шалгаруулсан байна. /Арга хэмжээнд хамрагдагсдын тоо-92/ /Зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдагсдын тоо-132/ Энэхүү үйл ажиллагааны хүрээнд 224 ирэгсдэд үйлчилж, 25 уншигчийг шинээр бүртгэж, 55 уншигчийн үйлчилгээний	100

				эрхийг сунгаж, Утга уран зохиол судлал, Түүх, Уран зохиол, Байгалийн шинжлэх ухаан зэрэг салбар шинжлэх ухааны нийт 240 номыг уншлагад гаргасан байна.	
9.4.1.3 Хүүхдийг хөдөлмөрт сургах, хамтарч ажиллах чадвар эзэмшүүлэх зорилгоор "Хөдөлмөр зуслан"-ын үйл ажиллагааг эхлүүлэх	Хөдөлмөр зуслангийн тоогоор	-	1	Есөнзүйл суманд Хүүхдийн хөдөлмөр зуслангийн бүтээн байгуулалтын ажил жил бүр шат дараатайгаар хийгдэхээр төлөвлөгдөөд явж байна. 2024 Онд бүтээн байгуулалтад 2 шовгор, 00 барих ажлын нийт 30 саяын тендерийг зарлан 29,5 сая төгрөгөөр гүйцэтгүүлэн ажилласан байна. 2025 онд нийт 50 сая төгрөгийн төсөв бүхий хөдөлмөр зусланг хашаажуулах ногоон байгууламж бий болгох тендер 2 удаа зарлагдсан боловч шаардлага хангасан гүйцэтгэгч байгаагүй учир хийгдээгүй байна. 2026 оны төсөвт хөдөлмөр зуслангийн бүтээн байгуулалтад 70 сая төгрөгийг төсөвлөн 2026 оны төсвийн төсөлд оруулж бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	100
9.4.2 Хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалтын түвшинд стандарт тогтоох холбогдох зохицуулалтыг бий болгоно.					
9.4.2.1 Цахим орчин дахь хүүхдэд үл тохирох контентэд хяналт тавьж, хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах	Эерэг контент, шторкны тоо	-	2	Ерөнхий боловсролын сургуулийн эцэг эхчүүдтэй хамтран сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, алдаршуулах зорилгоор видео контент хийж сургуулийн цахим хуудсанд байршуулсан.	100
9.4.2.2 Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах	Сургалт, арга хэмжээний тоо	2	3	Сургуулийн нийгмийн ажилтантай хамтран Сэргийлэгч хүү, Зөвлөгч охины дүрийг бүтээн сургуулийн орчинд байршуулж, сургуулийн сурагчдад үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан	90

				сэргийлэх үйл ажиллагаа болон мэдээ мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдрийн хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Сургуулийн дотуур байрны эцэг эхчүүдийн өдөрлөгөөр Хүүхэд хүмүүжлийн эерэг аргын хэвлэмэл, боршур тарааж өглөө.	
9.4.2.3 Цахим орчинд хүүхэд, гэр бүлийн зүй зохистой харилцааны талаарх мэдээллийг түгээж гэр бүлд ээлтэй бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Контент, Постер, Подкаст шторкын тоо	-	8	2025 оны 05-р сарын 23-ны өдөр Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас төлөөлөгчдийн нэрэмжит "НЭГ ГЭР БҮЛ, НЭГ ХАМТ ОЛОН" уриатай гэр бүлийн өдөрлөг зохион байгууллаа. 2025 оны 05-р сарын 15-ны өдөр ЕБС-ийн хамт олон нь байгууллагын ЕБС-д суралцдаг хүүхдүүд, ажилладаг эцэг эхчүүдийн дунд "Бид хүүхдээ хэрхэн мэддэг вэ?" үйл ажиллагаа зохион байгууллаа. Нийт 24 эцэг эх, 24 хүүхэд асуулгад оролцлоо. Энэ үйл ажиллагаанд оролцсон эцэг эхчүүдийг сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, алдаршуулах зорилгоор видео контент хийж сургуулийн цахим хуудсанд байршуулсан.	100
9.5.2 Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилна.					
9.5.2.1 Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах	Зохион байгуулсан үйл ажиллагаа	-	20	Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор Засаг даргын Тамгын газарт нээлттэй утсыг ажлын найман цагаар ажиллуулан иргэдийн санал хүсэлт болон авлигын талаарх мэдээллийг иргэд чөлөөтэй мэдээлэх боломж нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн Засаг даргын Тамгын газрын "Өвөрхангай Есөнзүйл ЗДТГазар" нэртэй фейсбүүк хаяг, Esunzuil.ov.gov.mn нэртэй пэйж	100

				хуудсаар иргэдээс санал хүсэлтийг 24 цагийн турш аван ажиллаж байна.	
10.2.3.1 Гамшгаас хамгаалах болон онц байдлын үеийн хандив, тусламжийг бүртгэх, зарцуулалтыг ил тод болгох, хяналт тавих олон нийтэд нээлттэй цахим системийг нэвтрүүлнэ.					
10.2.4.1 Хандивыг төрийн сангийн дансанд төвлөрүүлж, зарцуулалтыг тухай бүр олон нийтэд ил тод тайлагнах	Ил тод болгосон мэдээллийн тоо	-	Тухай бүр байршуулсан байна.	Сумын Засаг даргын Тамгын газарт 2025 онд мөнгөн хандив ирээгүй. Улс, аймгийн аварга болсон малчид нийт 60 толгой хонь сумын Засаг даргын Тамгын газарт хандивласан байна. Зарцуулалтыг тухай бүр тайлагнан ажиллаж байна.	100
Хоёр. Бусад. Орон нутгийн төрийн байгууллага, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлнэ.					
2.1 Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сум, агентлаг, төсөвт байгууллагуудын удирдах ажилтнуудад АТГ-тай хамтран сургалт, уулзалт зохион байгуулах	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	200 удирдах ажилтан хамрагдсан	250 доошгүй төсвийн шууд захирагч нарыг хамруулсан байна.	Төсвийн шууд захирагч болон төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр заалт тусган, үр дүнг жил бүр тооцон ажилласны үр дүнд авлига, ашиг сонирхлын зөрчил дутагдал илрээгүй байна. 2025 оны байдлаар Авлигатай тэмцэх газарт 3 албан хаагчийн ХАСУМ-ыг хянуулан албан бичгийг нь авч хууль тогтоомжийн хүрээнд албан тушаалд томилон ажиллаж байна. 2024 оны 02 дугаар сарын 15-ны дотор ХОСХОМ гаргах эрх бүхий албан тушаалтнууд 100% хугацаанд нь зөрчилгүй хөрөнгө орлогын мэдүүлгийг системд оруулан тайлан мэдээг хугацаанд нь дээд байгууллагад хүргүүлэн ажиллалаа.	100
2.2 Авлигатай тэмцэх газраас зарласан аян нөлөөллийн үйл ажиллагаатай уялдуулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён	Зохион байгуулсан арга хэмжээ	"Нэгдье аян"	"Нээлттэй өдөрлөг" зохион байгуулах	"Нэгдье аян"-ы хүрээнд Мөнхбулагийн багийн иргэд нийтийн хурал, сумын 2025 оны малчдын зөвлөгөөнд ирсэн иргэдэд авлигын тухай хууль тогтоомжийг сурталчлан ажиллаж Авлигатай тэмцэх	100

гэгээрүүлэх сургалт, сурталчилгааг хийх				газраас гаргасан шторк, видео контентуудыг иргэдэд үзүүлэн сурталчлан ажиллалаа.	
2.3 Төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хороодтой хамтран ажиллаж, мэдээлэл солилцон, ёс зүйн зөрчил гарч буй байгууллагуудад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах.	Шинэчлэн байгуулагдсан ёс зүйн дэд хорооны тоо	-	42	Засаг даргын Тамгын газар нь сумын бүх төрийн байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүдэд Ёс зүйн тухай хууль болон, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын талаар сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтаар Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа болон цахим системд мэдээлэл байршуулах гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх талаарх мэдээллийг өгөн ажиллалаа. Мөн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад Ёс зүйн тухай хууль болон, Төрийн албаны Ёс зүйн хэм хэмжээний талаар сургалтыг зохион байгуулан ажиллалаа. Тус сургалтуудад нийт 50 гаруй тэтгэвэр тэтгэмж авч буй иргэд 60 гаруй төрийн албан хаагчид хамрагдаад байна.	100
Ерөнхий үнэлгээ					98,3

ХЯНАСАН: ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЕСӨНЗҮЙЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА  Ц.МЯГМАРСҮРЭН

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЕСӨНЗҮЙЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  С.БАТ-ЭРДЭНЭ